

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/50/СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойр хот  
2022 он

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа  
Утас: 70543156  
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn  
Аудитын менежер: Г.Наранбаяр  
Утас: 70543179  
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn  
Аудитор: С.Батцэцэг  
Утас: 70543179  
Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
4.1 Залруулсан алдаа .....	18
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	23

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОУБ	Олон улсын байгууллага



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг  
Утас/Факс: 976-7054 3179  
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2022.01.25 № 44  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г СҮМБЭР СУМЫН "5 ДУГААР  
ЦЭЦЭРЛЭГ"-ИЙН ТӨСВИЙН  
ЗАХИРАГЧ Ц.СОЁЛМАА ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүмбэр сумын "5 дугаар цэцэрлэг"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүмбэр сумын "5 дугаар цэцэрлэг"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Сүмбэр сумын "5 дугаар цэцэрлэг"-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар залруулагдаагүй 14,658.4 мянган төгрөгийн дараах алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 11,095.0 мянган төгрөгөөр их байна.

- Багш нарын ур чадвар, албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг 5,894.5 мянган төгрөгөөр илүү тооцож байна.
- Хууль, тогтоомжинд заагдаагүй дотоод журмын дагуу олгосон буцалтгүй тусламж, тэтгэмж, урамшууллаас 86.0 мянган төгрөгийн ХХОАТ-ын суутгал тооцоогүй олгосон.
- Худалдан авалт хийхдээ гэрээ байгуулаагүй, урсгал засвар хийх зардлыг хуурамч баримт бүрдүүлэн өөр зардалд зарцуулж, бараа материалын тайланд биетээр худалдан аваагүй 7,795.0 мянган төгрөгийн хөрөнгийг хий орлого бүртгэж, зарлагаар тайлагнасан, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан.

008020133

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.9 дэх заалт, УСНББОУС-14, ХХОАТ-ын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтыг зөрчсөн ба “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/ төгрөгөөр /	
№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>72,802,386.51</b>	<b>79,220,601.25</b>	
<b>2</b>	<b>АВЛАГА</b>	<b>969,082</b>	<b>514,214</b>	
3	Бусад авлага	969,082	514,214	
4	Хувь хүмүүсээс авах авлага	969,082	514,214	
<b>5</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>71,833,304.51</b>	<b>78,706,387.25</b>	
6	Хангамжийн материал	71,833,304.51	78,706,387.25	
7	Бичиг хэргийн материал		131,250	
8	Аж ахуйн материал	65,571,153.95	75,343,186.69	
9	Хүнсний материал	1,689,150.56	3,231,950.56	
10	Бусад хангамжийн материал	4,573,000		
<b>11</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>658,751,797</b>	<b>588,404,838.59</b>	
<b>12</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>658,751,797</b>	<b>588,404,838.59</b>	
13	Биет хөрөнгө	585,215,297	515,013,838.59	
14	Барилга, байгууламж, орон сууц	568,502,005.94	504,249,822.93	
15	Хуримтлагдсан элэгдэл	-22,474,961.53	-18,602,233.12	
16	Машин тоног төхөөрөмж(компьютер)	14,737,542.7	15,259,947.7	
17	Хуримтлагдсан элэгдэл	-5,190,928.8	-8,714,067.53	
18	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,509,800.75	11,509,800.75	
19	Хуримтлагдсан элэгдэл	-6,972,147.65	-8,353,292.73	
20	Бусад үндсэн хөрөнгө	37,526,009	37,526,009	
21	Хуримтлагдсан элэгдэл	-14,883,661.61	-20,323,786.61	
22	Ном	2,461,638.2	2,461,638.2	
23	Биет бус хөрөнгө	73,536,500	73,391,000	
24	Програм хангамж	17,582,000	17,582,000	
25	Хуримтлагдсан элэгдэл	-145,500	-291,000	
26	Бусад биет бус хөрөнгө	56,100,000	56,100,000	
<b>27</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>731,554,183.51</b>	<b>667,625,439.84</b>	
<b>28</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>731,554,183.51</b>	<b>667,625,439.84</b>	
29	Засгийн газрын хувь оролцоо	731,554,183.51	667,625,439.84	
30	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	670,721,522.76	670,721,522.76	
32	Хуримтлагдсан үр дүн	-61,050,269.79	-94,305,278.65	
33	Өмнөх үеийн үр дүн	-74,540,591.96	-74,024,768.74	
34	Тайлант үеийн үр дүн	13,490,322.17	-20,280,509.91	
35	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	121,882,930.54	91,209,195.73	
<b>36</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>731,554,183.51</b>	<b>667,625,439.84</b>	

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

		/ төгрөгөөр /	
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>489,025,139</b>	<b>502,872,728.74</b>
<b>2</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>38,793,139</b>	<b>6,695,528.74</b>
3	Нийтлэг татварын бус орлого	38,793,139	6,695,528.74
4	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	31,048,884	522,405
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,744,255	6,173,123.74
<b>6</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>450,232,000</b>	<b>496,177,200</b>
7	Улсын төвлөрсөн төсвөөс	385,817,800	434,880,100
8	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,817,800	434,880,100
9	Нэмэлт санхүүжилтийн орлого		160,000
10	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		160,000
11	Орон нутгийн төсвөөс санхүүжих	64,414,200	61,137,100
12	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,414,200	61,137,100
<b>13</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>475,127,686.83</b>	<b>523,153,238.65</b>
<b>14</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>475,127,686.83</b>	<b>523,153,238.65</b>
<b>15</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>435,537,238.83</b>	<b>516,915,090.77</b>
<b>16</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>276,424,161.31</b>	<b>355,775,405.12</b>
17	Үндсэн цалин	276,041,127.31	353,013,656
18	Нэмэгдэл		2,689,749.12
19	Унаа хоолны хөнгөлөлт		72,000
20	Урамшуулал	383,034	
<b>21</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,162,243.39</b>	<b>46,642,755</b>
22	Тэтгэврийн даатгал	23,629,699.39	33,034,725.08
23	Тэтгэмжийн даатгал	2,773,788	3,621,696.98
24	ҮОМШӨ-ний даатгал	2,212,311	2,853,677.98
25	Ажилгүйдлийн даатгал	497,487	632,424
26	Эрүүл мэндийн даатгал	5,048,958	6,500,230.96
<b>27</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,028,223</b>	<b>42,458,440</b>
28	Гэрэл, цахилгаан	5,145,329	4,817,302
29	Түлш, халаалт	24,819,409	28,438,138
30	Цэвэр, бохир ус	4,063,485	9,203,000
<b>31</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,673,640.01</b>	<b>3,706,530</b>
32	Бичиг хэрэг	839,690	1,537,050
33	Тээвэр, шатахуун	400,000	752,000
34	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000	1,273,280
35	Ном, хэвлэл		144,200
36	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	386,400	
37	Бараа материал акталсны зардал	24,647,550.01	

Говьсүмбэр аймгийн “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>38</b>	<b>Нормативт зардал</b>	<b>38,466,837</b>	<b>22,833,520</b>
39	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	124,000	292,500
40	Хоол, хүнс	38,342,837	22,541,020
41	Эд хогшил, урсгал засварын зардал	373,500	11,400,120
42	Урсгал засвар	373,500	11,400,120
43	Томилолт, зочны зардал	124,600	160,100
44	Дотоод албан томилолт	124,600	160,100
<b>45</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,069,700</b>	<b>1,263,900</b>
46	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	769,700	1,043,900
47	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000	
48	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	220,000
<b>49</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,214,334.12</b>	<b>32,674,320.65</b>
50	Бараа үйлчилгээний бусад зардал	2,060,150	5,043,191
51	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	120,000	410,000
52	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,034,184.12	27,221,129.65
<b>53</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,590,448</b>	<b>6,238,147.88</b>
<b>54</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,120,000</b>	<b>860,000</b>
55	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,120,000	860,000
56	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	28,174,977	5,362,660
57	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,174,977	5,362,660
58	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,295,471	15,487.88
59	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,295,471	15,487.88
<b>60</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>13,897,452.17</b>	<b>-20,280,509.91</b>
<b>61</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>407,130</b>	
62	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	407,130	
<b>63</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>13,490,322.17</b>	<b>-20,280,509.91</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/ төгрөгөөр /
№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	670,721,522.76	121,882,930.54	-74,540,591.96	718,063,861.34
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	670,721,522.76	121,882,930.54	-74,540,591.96	718,063,861.34
3	Тайлант үеийн үр дүн			13,490,322.17	13,490,322.17
<b>4</b>	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>670,721,522.76</b>	<b>121,882,930.54</b>	<b>-61,050,269.79</b>	<b>731,554,183.51</b>
<b>5</b>	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>670,721,522.76</b>	<b>121,882,930.54</b>	<b>-61,050,269.79</b>	<b>731,554,183.51</b>
6	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-12,974,498.95	-12,974,498.95
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	670,721,522.76	121,882,930.54	-74,024,768.74	718,579,684.56
8	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-30,673,734.81		-30,673,734.81
9	Тайлант үеийн үр дүн			-20,280,509.91	-20,280,509.91
<b>10</b>	<b>2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>670,721,522.76</b>	<b>91,209,195.73</b>	<b>-94,305,278.65</b>	<b>667,625,439.84</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>450,232,000</b>	<b>496,177,200</b>
2	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>450,232,000</b>	<b>496,177,200</b>
3	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>385,817,800</b>	<b>434,880,100</b>
4	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	385,817,800	434,880,100
5	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>160,000</b>
6	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		160,000
7	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>64,414,200</b>	<b>61,137,100</b>
8	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	64,414,200	61,137,100
9	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>450,232,000</b>	<b>496,177,200</b>
10	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>450,232,000</b>	<b>496,177,200</b>
11	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>410,641,552</b>	<b>489,939,052.12</b>
12	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>276,604,245</b>	<b>355,925,332.12</b>
13	Үндсэн цалин	198,773,100	209,703,842
14	Нэмэгдэл	44,962,632	111,116,531.12
15	Унаа хоолны хөнгөлөлт	4,462,505	12,289,943
16	Урамшуулал	28,406,008	22,815,016
17	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>34,147,334</b>	<b>46,037,960</b>
18	Тэтгэврийн даатгал	22,467,183	28,895,311.32
19	Тэтгэмжийн даатгал	3,662,200	4,290,947.92
20	ҮОМШӨ-ний даатгал	2,929,700	6,321,885.14
21	Ажилгүйдлийн даатгал	732,500	876,993.78
22	Эрүүл мэндийн даатгал	4,355,751	5,652,821.84
23	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,028,223</b>	<b>42,458,440</b>
24	Гэрэл, цахилгаан	5,145,329	4,817,302
25	Түлш, халаалт	24,819,409	28,438,138
26	Цэвэр, бохир ус	4,063,485	9,203,000
27	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>15,228,200</b>	<b>1,522,600</b>
28	Бичиг хэрэг		198,300
29	Тээвэр, шатахуун	400,000	752,000
30	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,400,000	146,000
31	Ном, хэвлэл		144,200
32	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,428,200	282,100
33	<b>Нормативт зардал</b>	<b>41,361,850</b>	<b>25,648,820</b>
34	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	320,000	292,500
35	Хоол, хүнс	29,269,050	24,083,820
36	Нормын хувцас, зөөлөн эдлэл	11,772,800	1,272,500
37	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,211,000</b>	<b>13,316,000</b>
38	Урсгал засвар	2,211,000	13,316,000

Говьсүмбэр аймгийн “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39	Томилолт, зочны зардал	124,600	160,100
40	Дотоод албан томилолт	124,600	160,100
<b>41</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,069,700</b>	<b>1,595,400</b>
42	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	769,700	1,375,400
43	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,080,000	
44	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	220,000
45	Бараа үйлчилгээний бусад зардал	4,866,400	3,274,400
46	Бараа үйлчилгээний бусад зардал	3,546,400	1,394,400
47	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,320,000	1,880,000
<b>48</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>39,590,448</b>	<b>6,238,147.88</b>
<b>49</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,120,000</b>	<b>860,000</b>
50	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,120,000	860,000
<b>51</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>28,174,977</b>	<b>5,362,660</b>
52	Төвлөрүүлэх шилжүүлэг	28,174,977	5,362,660
53	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,295,471	15,487.88
54	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,295,471	15,487.88
<b>55</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>		
<b>56</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>		

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>496,017,200</b>	<b>490,639,052.12</b>	<b>5,378,14.88</b>
2	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>496,017,200</b>	<b>490,639,052.12</b>	<b>5,378,14.88</b>
3	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>495,157,200</b>	<b>489,779,052.12</b>	<b>5,378,14.88</b>
4	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>355,926,400</b>	<b>355,925,332.12</b>	<b>1,067.88</b>
5	Үндсэн цалин	228,481,000	209,703,842	18,777,158.00
6	Нэмэгдэл	105,546,500	111,116,531.12	-5,570,031.12
7	Унаа хоолны хөнгөлөлт	3,544,600	12,289,943	-8,745,343.00
8	Урамшуулал	18,354,300	22,815,016	-4,460,716.00
9	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,038,100</b>	<b>46,037,960</b>	<b>140.00</b>
10	Тэтгэврийн даатгал	21,809,400	28,895,311.32	-7,085,911.32
11	Тэтгэмжийн даатгал	4,396,900	4,290,947.92	105,952.08
12	ҮОМШӨ-ний даатгал	10,158,300	6,321,885.14	3,836,414.86
13	Ажилгүйдлийн даатгал	879,500	876,993.78	2,506.22
14	Эрүүл мэндийн даатгал	8,794,000	5,652,821.84	3,141,178.16
15	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>47,821,100</b>	<b>42,458,440</b>	<b>5,362,660.00</b>
16	Гэрэл, цахилгаан	8,000,000	4,817,302	3,182,698.00
17	Түлш, халаалт	30,618,100	28,438,138	2,179,962.00
18	Цэвэр, бохир ус	9,203,000	9,203,000	0
19	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,522,600</b>	<b>1,522,600</b>	<b>0</b>
20	Бичиг хэрэг	198,300	198,300	0
21	Тээвэр, шатахуун	752,000	752,000	0
22	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	146,000	146,000	0
23	Ном, хэвлэл	144,200	144,200	0
24	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	282,100	282,100	0
25	<b>Нормативт зардал</b>	<b>25,503,100</b>	<b>25,488,820</b>	<b>14,280.00</b>
26	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	132,500	132,500	0
27	Хоол, хүнс	24,098,100	24,083,820	14,280.00
28	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,272,500	1,272,500	0
29	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,316,000</b>	<b>13,316,000</b>	<b>0</b>
30	Урсгал засвар	13,316,000	13,316,000	0
31	Томилолт, зочны зардал	160,100	160,100	0
32	Дотоод албан томилолт	160,100	160,100	0
33	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,595,400</b>	<b>1,595,400</b>	<b>0</b>

Говьсүмбэр аймгийн “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

34	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,375,400	1,375,400	0
35	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000	220,000	0
36	Бараа үйлчилгээний бусад зардал	3,274,400	3,274,400	0
37	Бараа үйлчилгээний бусад зардал	1,394,400	1,394,400	0
38	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,880,000	1,880,000	0
<b>39</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>860,000</b>	<b>860,000</b>	<b>0</b>
<b>40</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>860,000</b>	<b>860,000</b>	<b>0</b>
41	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	860,000	860,000	0
<b>42</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>496,017,200</b>	<b>490,639,052.12</b>	<b>5,378,14.88</b>
<b>43</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>434,880,100</b>	<b>434,864,612.12</b>	<b>15,487.88</b>
45	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	434,880,100	434,864,612.12	15,487.88
<b>46</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>61,137,100</b>	<b>55,774,440</b>	<b>5,362,660.00</b>
47	Орон нутгийн төсвөөс	61,137,100	55,774,440	5,362,660.00
48	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	317	317	
49	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	
50	Төсвийн байгууллага	1	1	
51	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24	24	
52	Удирдах ажилтан	1	1	
53	Гүйцэтгэх ажилтан	13	13	
54	Үйлчлэх ажилтан	10	10	
55	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	268	268	
56	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	268	268	
57	Төрийн өмчит СӨБ байгууллага	268	268	
58	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24	24	
59	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	14	14	
60	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>160,000</b>	<b>-160,000</b>
3	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>160,000</b>	<b>-160,000</b>
4	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>160,000</b>	<b>-160,000</b>
5	Нормативт зардал		<b>160,000</b>	<b>-160,000</b>
6	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал		160,000	-160,000
7	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>160,000</b>	<b>-160,000</b>
8	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>160,000</b>	<b>-160,000</b>
9	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		160,000	-160,000

### 3. Аудитын тайлан

---

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг”-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгийн ашиглалт, шилэн дансны хугацаа, орон тооны мэргэжлийн багш нартай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Батцэцэг гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын захирал дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг”-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” нь монгол хүний сэтгэлгээ, монгол уламжлал, ёс заншил, соёл түүхийг таниулж, сургалтын хөтөлбөрт тусгаж хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаагаар олгоход багшийн арга зүй, ур чадварыг ахиулах, дугуйлангийн үйл ажиллагааг сайжруулах юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “нийт зардал” сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх нийт зардал 475,127.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,751.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3,563.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг”-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63,928.8 мянган төгрөгөөр буюу 8.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүний дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	969.1	514.2	-454.9
Бараа материал	71,833.3	78,706.4	6,873.1
Үндсэн хөрөнгө	658,751.8	588,404.8	-70,347.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>731,554.2</b>	<b>667,625.4</b>	<b>-63,928.8</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	670,721.5	670,721.5	0.0
Хуримтлагдсан үр дүн	-61,050.2	-94,305.3	-33,255.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	121,882.9	91,209.2	-30,673.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>731,544.2</b>	<b>667,625.4</b>	<b>-63,928.8</b>

Авлагын дансны үлдэгдэл болох 514.2 мянган төгрөг нь өмнөх жилүүдэд хуримтлагдсан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78,706.4 мянган төгрөг болж 6,873.1 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал болон хүнсний материалын худалдан авалтаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 588,404.8 мянган төгрөг болж 70,347.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмэгдсэн, барилгын дахин үнэлгээний хийгдэж үнэ буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө нь тайлант хугацаанд нийт 472,639.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 147 дугаар албан бичгээр барилгын дахин үнэлгээг хийсэн, мөн “Дэлхийн зөн” ОУБ-аас 1 принтерийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Хуучин барилгын үнэлгээ болох 536,369.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө хасагдсан байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл 94,305.3 мянган төгрөг болж, 33,255.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн зардал өссөн, хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүнээс шалтгаалжээ.

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү дансны үлдэгдэл 91,209.2 мянган төгрөг болж, 30,673.7 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнээс шалтгаалжээ.

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг”-ийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 13,847.6 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Нийт зардал өмнөх оноос 48,025.5 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, тогтмол зардал, урсгал засварын зардал, бараа ажил үйлчилгээ бусад зардлууд нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлтийн залруулга нь 12,974.5 мянган төгрөгөөр өмнөх үеэс буурсан нь 2018 онд барилгыг дахин үнэлж бүртгээгүйг тайлант онд бүртгэж залруулга хийгдсэн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,216,963.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,216,963.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 454,449.3 мянган төгрөгөөр бууруулж 762,514.1 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төслөөс бууруулж баталсан нь цалин хөлс, тогтмол зардал, эд хогшил, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх

ажил, үйлчилгээний зардлыг өмнөх оноос шинэ барилгууд ашиглалтад орохтой холбоотойгоор нэмэгдүүлж төлөвлөснөөс шалтгаалсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71801 /Сургуулийн өмнөх боловсрол/ хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 762,514.1 мянган төгрөгийн төсөв баталснаас төсвийн хуваарийг 5 удаагийн өөрчлөлт орсны дараа нийт 496,017.2 мянган төгрөгийн санхүүжилтийг өгснөөс 434,880.1 мянган төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 61,137.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 496,017.2 мянган төгрөгөөс тусгай зориулалтын шилжүүлгээс 434,880.1 мянга, орон нутгийн төсвөөс 61,137.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 490,639.0 мянган төгрөгийг зарцуулж, 5,378.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 490,639.0 мянга буюу 99 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 1.1 мянга, тогтмол зардлаас 5,362.7 мянга, нормативд зардлаас 14.4 мянган төгрөгөөр тус тус дутуу /хэмнэсэн/ зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлыг дутуу зарцуулсан нь 71801 хөтөлбөрийн 3 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд 5,362.7 мянган төгрөгийн бодит хэмнэлт гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас 160.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардалд 160.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

“Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” нь 2021 онд нийт 496,177.2 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан ба 17 мэдээлэл хоцроосон зөрчил илэрсэн тул зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгахад хуульд нийцсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 72,933.3 мянган төгрөгийн 11 алдаа, зөрчил илэрснээс 69,025.3 мянган төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 360.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 3,548.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгөгдсөн бөгөөд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	-	-	-
Албан шаардлага	1	3,548.0	1	3,548.0			
Төлбөрийн акт	1	360.0	1	360.0			
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>3,908.0</b>	<b>3</b>	<b>3,908.0</b>			-

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 522,378.8 мянган төгрөгийн 22 алдаа зөрчил илэрснээс, 3,485.5 мянган төгрөгийн 4 алдааг завсрын аудитаар, 493,858.9 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 20,266.4 мянган төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 4,767.9 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүллээ.

#### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай нийт 497,344.4 мянган төгрөгийн залруулгаас 3,485.5 завсрын аудитаар, 493,858.9 мянган төгрөгийн залруулгыг аудитын явцад залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын тайланг хөдөлгөөн гараагүй ч үлдэгдэлтэй тайланг сар бүр тайлан гаргах зөвлөмж өгсний дагуу залруулга хийгдсэн.
2. "Дэлхийн Зөн" ОУБ-аас хандивласан эргэлтийн хөрөнгийг бараа материал тодруулгын тайланд ангилал зөрүүтэй тайлагнасан 1,875.3 мянган төгрөгөөр залруулга хийгдсэн.
3. Барилга байгууламж, тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл, номын фонд, программ хангамж, бусад биет бус хөрөнгийн нярвын тайланг гаргаагүйг улирал бүр үлдэгдэлтэй тайланг гаргах талаар завсраар өгсөн зөвлөмжийн дагуу залруулсан.
4. Өглөг, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 1,610.2 мянган төгрөгөөр залруулсан.
5. Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн 5,362.7 мянган төгрөгийн тохируулга хийгээгүй залруулга хийгдсэн.
6. Эм боох, түлш, шатах тослох материал, барилгын материалын тайлангуудыг ангилал зөрүүтэй бүртгэсэн 15,933.5 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.
7. Цалингийн зардал бууруулж бичсэн 445.2 мянган төгрөгийн залруулга хийгдсэн.
8. Барилга байгууламжид 2018 оны дахин үнэлгээ хийгдээгүй байсныг 2021 онд ОНӨГ-аас албан тоот өгсний дагуу дахин үнэлсэн боловч дансны бичилт буруу хийгдсэн 472,117.5 мянган төгрөгийн залруулсан.

#### 4.2 Төлбөрийн акт

4.2.1. Санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй үр дүнгийн урамшууллыг эрхлэгчид 2020 оны үр дүнгийн урамшууллыг давхардуулан 882.9 мянга, багш нарын ур чадвар, албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг нийт 5,894.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон, тогтоомжид тусгайлан заагдаагүй, дотоод журмын хүрээнд олгосон буцалтгүй тусламж, тэтгэмжээс 86.0 мянган төгрөгийн ХХОАТ суутган тооцоогүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Төрийн албаны тухай хуулийн 51.1.4, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22.1.1, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралт 2.1, 4.3, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4, Боловсрол, шинжлэх ухааны сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10,9 дүгээр тушаалын 10, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны А/261 дугаар тушаалын хавсралтын 2.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3, 4.2.3.6, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

4.2.2. Тайлант оны 12-р сард төсөв хоорондын шилжүүлэг хийж, урсгал засварын зардалд 10.0 сая төгрөгийг шилжүүлэн эрх авч зарцуулсан боловч худалдан авалт хийхдээ гэрээ байгуулаагүй урсгал засвар хийх 7,795.0 мянган төгрөгийн зардлыг хуурамч баримт бүрдүүлэн өөр зардалд зарцуулж, бараа материалын тайланд биетээр

худалдан аваагүй хөрөнгийг хий орлого бүртгэж, зарлагаар тайлагнасан, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг байх, оршин байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.6, 4.2.3.8-т заасны дагуу төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

**4.3.1** Татварын цахим бүртгэлийн системд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтыг тулган баталгаажуулаагүйгээс 1,624.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.5, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5 дах заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.3.2** Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэргүйгээр батлагдсан орон тоог нэмэгдүүлсэн, үндэслэлгүй нэмэгдүүлсэн орон тооны тушаалаар хавсарсан ажлын нэмэгдэлд 1,836.6 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 14 дүгээр зүйлийн 14.2.12, 16 дугаар зүйлийн 16.5.3, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.20 дэх заалтуудыг тус тус зөрчсөн ба эрх ба үүрэг байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.3.3** Эдийн засгийн ангилал зөрчиж цэвэр бохир усны зардлаас хог хаягдлын төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардалд, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас интернетийн төлбөр болох нийт 1,307.3 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", 2021 оны 190 дүгээр тушаалыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу албан шаардлага өгөв.

**4.3.4** Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэл, тайлагналыг хуулийн хүрээнд үнэн зөв хөтлөөгүй, төсөв санхүүгийн сахилга хариуцлага алдсан, хууль тогтоомж зөрчин ажил гүйлгээг бүртгэж, тайлагнасан нь Төрийн албаны тухай

хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.14, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх заалтыг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны 95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т заасны дагуу нягтлан бодогчид хариуцлага тооцох шаардлага өгөв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг актлах болон дахин үнэлж ашиглаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг зөрчсөн ба “иж бүрэн байх, оршин байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх болон шаардлага хангаагүй үндсэн хөрөнгийг актлах ажлыг зохион байгуулах

##### **2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 17 мэдээллийг хугацаа хоцроосон нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

###### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Цаашид шилэн дансны мэдээллийг хугацаанд оруулж, хяналт тавьж ажиллах

##### **3. Хүний нөөцтэй холбоотой асуудал**

###### **3.1. Илрүүлэлт:**

Өөр байгууллагын үндсэн ажилтныг өөрийн байгууллагад дуу хөгжим, бүжгийн багшийн ажлыг гүйцэтгүүлэн зэрэгцүүлсэн гэрээ байгуулж хууль тогтоомж зөрчиж ажилласан нь Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй байна.

###### **3.2. Өгсөн зөвлөмж:**

Говьсүмбэр аймгийн “Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг” 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Цаашид орон тооны багш авч ажиллуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэг	21	522,378.8	9	497,344.4	5	20,266.4	5	4,767.9	3	-